



БАТЛАВ
"ДЦС-3" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Г.ДАМДИНСҮРЭН/

БАТЛАВ
"НЭГДЭЛ ТРЕЙД" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
/Л.ГЭНДЭНСҮРЭН/

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН РЕГУЛЯТОРУУД ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2017 оны 04-р сарын 12 ны өдөр

№ 2-4-178/7

Улаанбаатар хот

Ерөнхий зүйл

Нэг талаас "Дулааны 3 дугаар цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компани /цаашид "Захиалагч" гэх/-г төлөөлж Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер Ү.Төмөрхуяг, нөгөө талаас "Нэгдэл трейд" ХХК /цаашид "нийлүүлэгч" гэх/-ийг төлөөлж менежер Г.Мөнхсүлд нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон "ДЦС-3" ТӨХК-д Тусгай зориулалтын регуляторууд нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны 2017 оны 03-р сарын 28-ний өдрийн М-24-2017 дугаар хурлын шийдвэр, Үнэлгээний хорооны М-24/28/2017 дугаар зөвлөмжийг үндэслэн эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг баримтлан харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь М-24-2017 дугаартай Тусгай зориулалтын регуляторууд /цаашид "бараа" гэх/-г энэхүү гэрээний салшгүй хэсэг болох 1-р хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, стандартын дагуу СИП-Улаанбаатар "ДЦС-3" ТӨХК-ийн агуулах нөхцлөөр нийлүүлнэ.

Хоёр.Нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг тендерийн үндсэн баримтын дагуу гэрээнд хоёр талын гарын үсэг зурснаас хойш 25 хоногт багтаан нийлүүлнэ.

Гурав.Үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 94.068.250,00 /Ерэн дөрвөн сая жаран найман мянга хоёр зуун тавь/ төгрөг бөгөөд үнийн дүнд гааль, онцгой татвар, УБ "ДЦС-3" ТӨХК-ийн агуулах нөхцлөөр тээврийн зардал, НӨАТ бүгд багтсан байна.

3.2 Барааг нийлүүлсэн тохиолдолд хүлээн авсан барааны төлбөрийг Захиалагч Нийлүүлэгч талд 30 хоногт багтаан төлнө.

3.3 Захиалагч нь гэрээний үнийг гэрээний гүйцэтгэлийн баримт бичгийг үндэслэн Нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу Нийлүүлэгчийн дансанд төлнө.

Дөрөв.Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгчийн буруугаас бараа нийлүүлэх гэрээнд заасан хугацааг хожимдуулснаас Тоноглолын засварын хугацааг сунгах, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулах, хязгаарлахад хүрсэн бол үүнээс үүдэн гарсан хохирлыг Нийлүүлэгч нь захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

4.2 Нийлүүлэгчийн буруугаас бараа нийлүүлэх хугацааг хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба гэхдээ нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа нийлүүлэгчид захиалагч мэдэгдэнэ

- 4.3 Захиалагч нь бараа хүлээн авсны дараах төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.3 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба гэхдээ алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцохоо захиалагчид нийлүүлэгч бичгээр мэдэгдэнэ.
- 4.4 Хэсэгчлэн нийлүүлэгдээгүй барааны үнийн дүн гэрээний үнийн дүнгийн 25 хувиас их буюу бүх бараа нийлүүлэгдээгүй тохиолдолд энэхүү гэрээний 4.1 ба 4.2-т заасан хариуцлагаас Нийлүүлэгчийг чөлөөлөхгүй.
- 4.5 Барааг ДЦС-3 ТӨХК-ийн хашаанд ирсний дараа тус компанийн захиалагч цехийн ИТА барааг техникийн тодорхойлолтод заасан хэмжээнд хүрсэн эсэхийг шалгаж акт бүрдүүлэн хүлээн авна. Бараа техникийн үзүүлэлтэнд хүрээгүй тохиолдолд барааг буцааж гүйцэтгэлийн баталгааг нь Захиалагч тал нийлүүлэгч талд олгохгүй.

Тав.Бараа, бүтээгдэхүүний чанар, сав, баглаа боодол

- 5.1 Нийлүүлэх бараа нь 2016 оноос хойш үйлдвэрлэгдсэн, хадгалалтын үед хийгдэх үйлчилгээ хийгдсэн байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс бүрэн хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3 Бараа нь Захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд мөн шинж чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн барааны чанарт ямар нэг дутагдал илэрвэл түүний гзасах, сольж өгөхийг Захиалагч шаардах ба Нийлүүлэгч уул шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 12 сарын хугацааны баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, согогийг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.
- 5.6 Барааны баглаа, боодол дараах байдлаар хаяглагдсан байна.
- Гэрээний дугаар
 - Барааны нэр
 - Хүлээн авагчийн хаяг
- Барааг дараах бичиг баримт дагалдана.
- Савлалтын хуудас 3 хувь
 - Чанарын гэрчилгээ 3 хувь
 - Барааны гарал үүслийн гэрчилгээ 3 хувь

Зургаа.Барааг хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь бараа ачигдсан тухай нотлох бичиг баримтыг бараа ачигдсанаас хойш 48 цагийн дотор захиалагчид мэдэгдэнэ.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртлэх тээврийн болон бусад бүх зардлыг хариуцна.

Долоо.Давагдашгүй хүчин зүйлс

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улстөрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн буюу бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөлдөнө.

Найм.Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх хугацааг энэхүү гэрээнд зааснаас 10 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээ цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч нь гэрээг цуцлах эрхтэй ба Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгохгүй.
- 8.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж захиалагч тал 2 хувь, нийлүүлэгч тал 1 хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 9.5 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн аливаа оруулга, засвар, нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.6 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.
- Энэхүү гэрээ нь Үндсэн гэрээ 3 хуудас, Хавсралт 2 хуудас, нийт 5 хуудаснаас бүрдэнэ.

Арав.Талуудын хаяг

Захиалагч

Банк: ХХБ 806-р салбар
Төгрөгийн данс: 406001038
УБ хот, ХУД, 3-р хороо
ДЦС-3 ТӨХК-ийнбайр
Факс: 976-11-367288
Утас: 341990 , 70111304

Нийлүүлэгч

Банк: Голомт Банк
Төгрөгийн данс: 2205111962
УБ хот СХД, 2-р хороо,
Орбитын 46-20-21 тоот
Утас: 99141444, 91913956

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"ДЦС-3" ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
..... /У.ТӨМӨРХУЯГ/
СБХ-ИЙН ДАРГА
..... /Л.ДОРЖХОРЛОО/
ХХ-ИЙН ДАРГА
..... /Б.ЭРДЭНЭ/
СБХ-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН
..... /М.ЧУЛУУНЧИМЭГ/
ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
..... /Г.БАТНЯМ/
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
..... /М.ЭНХЗУЛ/

"НЭГДЭЛ ТРЕЙД" ХХК-ИЙН
МЕНЕЖЕР
..... /Г.МӨНХСҮЛД/



Handwritten signature in blue ink.



тоот гэрээний хавсралт №1

**ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН РЕГУЛЯТОРУУДЫН НЭР ТӨРӨЛ,
ТОО, ХЭМЖЭЭ, ҮНЭ**

№	Нэр төрөл	Барааны гарал үүсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду- 65 Ру-40 фланцтай	БНХАУ, Герман хамтарсан	ком	1	7,778,409.1	7,778,409.1
2	Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду-100 Ру-280	БНХАУ, Герман хамтарсан	ком	2	23,487,272.7	46,974,545.5
3	Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду-175 Ру-280	БНХАУ, Герман хамтарсан	ком	1	30,763,636.4	30,763,636.4
					ДҮН	85,516,590.9
					НӨАТ	8,551,659.1
					НИЙТ ҮНЭ	94,068,250.0

ХХ-ИЙН АХЛАХ ИНЖЕНЕР

[Signature] /Б.БИЛГҮҮДЭЙ/

ЗАХИАЛАГЧ:

[Signature]



НИЙЛҮҮЛЭГЧ:



ТООТ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №2

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан техникийн Доорхи стандартад заагдсан техникийн шаардлага өгөгдөлүүдийг нийлүүлэгчийн үйлдвэрээс ирүүлсэн баталгаат сертификатын техникийн үзүүлэлт өгөгдөлтэй харьцуулж шаардлага хангах эсэхийг шийдвэрлэнэ.

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду-175 Ру-280	Тэжээл 380в, оролт гаралтын сигнал 4-20ма, Хамгаалалтын зэрэг EN60529 стандартаар IP68-IP69 пульсээр удирдах боломжтой.	Актуатор нь AUMA брендийн актуатортай дүйцэхүйц чанар, техникийн үзүүлэлт функцтэй байна.
Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду-100 Ру-280	Тэжээл 380в, оролт гаралтын сигнал 4-20ма, Хамгаалалтын зэрэг EN60529 стандартаар IP68-IP69 пульсээр удирдах боломжтой.	Актуатор нь AUMA брендийн актуатортай дүйцэхүйц чанар, техникийн үзүүлэлт функцтэй байна.
Тохируулах хаалт иж бүрэн клапан, цахилгаан актуатор хамт Ду- 65 Ру-40 фланцтай	Тэжээл 220В, Оролт гаралт сигнал 4-20мА, Хамгаалалтын зэрэг EN60529 стандартаар IP68-IP69, пульсээр удирдагдах боломжтой.	Актуатор нь AUMA брендийн актуатортай дүйцэхүйц чанар, техникийн үзүүлэлт, функцтэй байна.

Жич: Ду-65 Ру-40 тохируулах хаалт иж бүрэн клапанын иж бүрдэлд:

1. Контроллёр: PID тохируулга бүхий 4-20мА 3-н оролттой 4-20мА гаралттай, релейний гаралттай, Тэжээл 220В,- 1ш
2. Төвшиний датчик: 10КПА, 4-20мА дифференциал трансмиситтер /штуцер, гурвалсан хаалтны хамт/- 1ш
3. Тэжээлийн блок: 24DCV, 10А -1ш тус тус орно.

ХХ-ИЙН АХЛАХ ИНЖЕНЕР

...../Б.БИЛГҮҮДЭЙ/

ЗАХИАЛАГЧ:

.....

